

## МОНГОЛ БА ЛАТИН АМЕРИК

Л.Хайсандай

Улс орноо өнөөгийн хямралт байдлаас гаргах, эдийн засгаа зах зээлийн харилцаанд шилжүүлэх гэж мэрийж байгаа энэ үед зах зээл амжилттай хөгжсөн буюу хөгжиж буй бага, дунд зэргийн орнуудын замнал, сургамж, туршлага, тэдгээртэй үр ашигтай хамтран ажиллах явдал манай улсын хувьд үлэмж ихээхэн ач холбогдолтой юм. Тийм улс орнуудын тоонд Азийн "Барнуудаас" гадна Латин Америкийн шинээр аж үйлдвэржсэн орнууд зүй ёсоор орно.

Өнөөдрийн байдлаар Монгол, Латин Америк хоёр бие биесээ сайн таньж мэдээгүй, ойртож хамтран ажиллах арга зам, ашиг сонирхлоо хараахан олж авч чадаагүй байна. Гэтэл манай орнуудын хооронд түүх, соёлын төдийгүй алт мөнгө, зэс, хүдэр, жонш, нүүрс зэрэг байгалийн төрөл бүрийн эрдэнэс баялаг, мал аж ахуйн гаралтай түүхий эдээрээ, тэдгээрийг боловсруулж ашигладаг ерөнхий төрх байдлаараа ч, хөгжлийн замд тулгарч буй бэрхшээл, түүнийг шийдвэрлэж, даван туулж, буй арга хэлбэрээрээ ч төстэй зүйл олон бий юм.

"Миний төрөл садан тэнд нутагладаг юм" хэмээн Чилийн их яруу найрагч Павло Неруда монгол түмний тухай бичсэн нь санаанаасаа зохиосон зүйл огт бишээ. Үнэхээр ч өнө эртний соёл иргэншилтэй төв Азийн монголчууд бидний төрөл садан тэртээ Латин Америкт олон үеийг улираан аж төрж суудагийг судалж үзвэл шинжлэх ухааны хувьд ч шинэ сонин судалгаа гарч болох юм.

Нөгөөтэйгүүр манай улсын далайд гарцтай болох гэж тэмүүлээд байгаа Номхон далайн маань зүүн ба зүүн өмнөд Латин Америкийн үлэмж хөгжсөн 11 орон шууд хөвөөлөн орших бөгөөд тэдгээр нь Ази, Номхон далайн олон улс оронтой худалдаа-эдийн засаг, соёлын харилцааг бүх

---

 Л.Хайсандай.

ШУА-ийн Зүүн хойт Ази судлалын төвийн тэргүүлэх ажилтан.

талаар хөгжүүлж, тус бүс нутгийн олон улсын хамтын ажиллагаанд хамгийн идэвхтэй оролцож, үр дүнтэй хамтран ажиллаж байгаа юм. Үүнээс харахад төмөр зам, агаарын тээврийн үнэ өртөг асар их өссөн өнөөгийн нөхцөлд Латин Америкийн зарим улстай далайн тээврээр шууд харилцаж хамтран ажиллавал зардлын хувьд хямд, олон орон гүрэн нэмжих явдалгүй хил гаалийн зүсэн зүйлийн бэрхшээл багатай байдал ажиглагдаж байна.

Мөн сүүлийн жилүүдэд Латин Америк нь дэлхийн олон шигшин анхаарлыг ихэд татах боллоо. Энэ нь юуны өмнө сүхэйн бүс нутгийн бие даасан 40 орчим улс гүрний дотроос анх зээлийн эдийн засгийн хөгжлөөрөө Чили, Бразил, Аргентин, Мексик, Уругвай, Венесуэл зэрэг орон, АНУ, Канад, Австрали, болон Япон, Хятад, Энэтхэг, Өмнө Солонгос зэрэг Азийн олон оронд Латин Америк судлалын идэсний төвүүд, тэдгээр улс оронтой төрөл бүрийн салбарт хамтран ажиллах хэдэн арван хороо, нийгэмлэг байгуулагдан ажиллаж байна. Эдгээрийг нэгтгэсэн дэлхийн бүс нутгийн чанартай байгууллагууд ч үйл ажиллагаагаа идэвхжүүлэн явуулж байна. Гэтэл Латин Америкийг "Алс холын" орнууд хэмээн үзчихээд ямарч идэвхи санаачилга, судалгаа, чиг баримтлалгүй сууцгааж байна. Чухам үнэндээ өнөөгийн хэмжүүрээр янз бүрийн байдлаар авч үзэхэд тогжлийн Латин Америкийн зам манайд илүү ойр дөт байж ч болох тал бий юм. Тиймд энэ оны 4-р сард ШУА-ийн Зүүн дунд Ази судлалын төвийн зарим эрдэмтдийн санаачилгаар, сүүний шууд ивээл дор манай оронд анх удаагийн Монголын Латин Америк судлал, хамтын ажиллагааны төв байгуулан ажиллуулж байна. Түүний гол зорилго нь Монгол Америкийн зарим тодорхой орны хооронд янз бүрийн салбарт харилцан ашигтай хамтран ажиллах боломж, арга замыг судалж хэрэгжүүлэх, ажил хэрэгч хүмүүс, байгууллагуудын хооронд хэлхээ холбоо тогтоож идэвхжүүлэхэд зуучилж тус дөхөм үзүүлэх, улмаар манайд хамтын үйлдвэрийн газар байгуулах, жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлээр энэ орнуудын хөрөнгө тус тус зээл тусламж оруулах ашиг сонирхол, итгэлийг бий болгох, улс орноо боломжтой хэлбэрээр тэнд сурталчлан танилцуулахад оршино.

хөгжүүлж, тус бүс нутгийн олон улсын хамтын ажиллагаанд хамгийн идэвхтэй оролцож, үр дүнтэй хамтран ажиллаж байгаа юм. Үүнээс харахад төмөр зам, агаарын тээврийн үнэ өртөг асар их өссөн өнөөгийн нөхцөлд Латин Америкийн зарим улстай далайн тээврээр шууд харилцаж хамтран ажиллавал зардлын хувьд хямд, олон орон гүрэн хамрагдах явдалгүй хил гаалийн зүсэн зүйлийн бэрхшээл багасгай байдал ажиглагдаж байна.

Мөн сүүлийн жилүүдэд Латин Америк нь дэлхийн олон улсын анхаарлыг ихэд татах боллоо. Энэ нь юуны өмнө бүс нутгийн бие даасан 40 орчим улс гүрний дотроос нь зээлийн эдийн засгийн хөгжлөөрөө Чили, Аргентин, Мексик, Уругвай, Венесуэл зэрэг орон, Канад, Австрали, болон Япон, Хятад, Энэтхэг, Өмнөд Африк зэрэг Азийн олон оронд Латин Америк судлалын төвсний төвүүд, тэдгээр улс оронтой төрөл бүрийн салбарт хамтран ажиллах хэдэн арван хороо, нийгэмлэг байгуулагдан ажиллаж байна. Эдгээрийг нэгтгэсэн дэлхийн бүс нутгийн чанартай байгууллагууд ч үйл ажиллагаагаа идэвхжүүлэн явуулж байна. Гэтэл Латин Америкийг "Алслагдсан" орнууд хэмээн үзчихээд ямарч идэвхи санаачилга, судалгаа, чиг баримтлалгүй сууцгааж байна. Чухам үнэндээ өнөөгийн хэмжүүрээр янз бүрийн байдлаар авч үзэхэд Латин Америкийн Латин Америкийн зам манайд илүү ойр дөт байж ч болох тал бий юм. Тиймд энэ оны 4-р сард ШУА-ийн Зүүн Ази судлалын төвийн зарим эрдэмтдийн санаачилгаар, түүний шууд ивээл дор манай оронд анх удаагийн Монголын Латин Америк судлал, хамтын ажиллагааны төв байгуулан ажиллуулж байна. Түүний гол зорилго нь Монгол Америкийн зарим тодорхой орны хооронд янз бүрийн салбарт харилцан ашигтай хамтран ажиллах боломж, цага замыг судалж хэрэгжүүлэх, ажил хэрэгч хүмүүс, байгууллагуудын хооронд хэлхээ холбоо тогтоож идэвхжүүлэхэд зуучилж тус дөхөм үзүүлэх, улмаар манайд хамтын үйлдвэрийн газар байгуулах, жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлээр энэ орнуудын хөрөнгө авч, зээл тусламж оруулах ашиг сонирхол, итгэлийг бий болгох, улс орноо боломжтой хэлбэрээр тэнд сурталчлан танилцуулахад оршино.

Тус төвийн эгнээнд төрөл бүрийн мэргэжлийн эрдэмтэн судлаач, урлаг соёлын зүтгэлтэн , ажил хэрэгч хүмүүс байгууллага эвлэлдэн нэгдэж, идэвхитэй хамтран ажиллаж эхэллээ. Энэ төв нь олон нийтийн байгууллага бөгөөд түүний хаалга ямагт нээлттэй, чөлөөтэй байх болно.